

ТАНЫ МЭДЛЭГТ

№01 2026.01.22

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗАР



Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах

1.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш **30 хоногийн дотор**, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн **02 дугаар сарын 15**-ны дотор шинэчлэн гаргаж Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.

2.Мэдүүлэг гаргагч заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр **30 хоногийн дотор** мэдүүлнэ.

3.Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй, хөрөнгө орлогын мэдүүлгийг заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол гаргаж өгөөгүйд тооцно.

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН 10 ДУГААР ЗҮЙЛЭЭС . . .

ТАНЫ МЭДЛЭГТ

№02 2026.01.28

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗАР



АВЛИГЫГ МЭДЭЭЛЭХ 110 ТУСГАЙ ДУГААР **1-110** БОЛЖ ӨӨРЧЛӨГДЛӨӨ

Авлигатай тэмцэх газрын ашиглаж буй авлигыг мэдээлэх 110 тусгай дугаар **1-110** болж өөрчлөгдлөө.

Авлигатай тэмцэх газрын одоо ашиглаж буй 110 тусгай дугаарыг **2026** оны **03** дугаар сарын **01**-ний өдрийг хүртэл **давхар ажиллуулах** бөгөөд **дээрх хугацаанаас хойш 110 дугаар хаагдаж, 1-110 дугаар** ердийн горимоор урьдын адил ажиллах юм.

Иймд иргэн, албан хаагч та бүхэн авлигыг мэдээлэх шаардлагатай үед **1-110** тусгай дугаарт холбогдох боломжтой.



1-110

Авлигыг мэдээлэх утас

ТАНЫ МЭДЛЭГТ

№03 2026.03.20

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗАР



Олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх нь

Соён гэгээрүүлэх:

Авлигын хор уршгийг сурталчлах, үл тэвчих ёс суртахууныг төлөвшүүлэх

Иргэдийн оролцоо:

Төрийн бус байгууллага, иргэдийн санаачилгыг дэмжих, тэдний оролцоог нэмэгдүүлэх,

Урьдчилан сэргийлэх:

Авлига гарах шалтгаан, нөхцөлийг судлах, илрүүлэх, таслан зогсоох,

Мэдээлэл ил тод байдал:

Авлигын индексийг олон нийтэд мэдээлэх,

Шударга байдал ёс зүй үнэ цэнийг бүтээдэг, шударга бус зүйлийн эсрэг нэгдье

Та авлига ашиг сонирхол, гомдол мэдээлэл хүлээн авах 11-10 тусгай дугаарт холбогдох боломжтой.

ТАНЫ МЭДЛЭГТ

№04 2026.04.27

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗАР



ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛЭГ БҮРЭН ЦАХИМЖЛАА

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хүлээн авах, хянах, хариу хүргүүлэх бүхий л үе шатыг **2026** оны **04** дүгээр сарын **15**-ны өдрөөс эхлэн бүрэн цахим хэлбэр (**meduuleg.iaac.mn**)-т шилжүүллээ.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн **ХАСУМ**-ийг **meduuleg.iaac.mn** цахим системээр албан тушаалын тодорхойлолтын хамт илгээх ба хянасан тухай хариуг мөн системээр хүлээн авснаар ХАСУМ-ийн хяналт дахь ил тод байдал нэмэгдэж, төрийн үйл ажиллагаа шуурхай болохын зэрэгцээ томилгоо хийхтэй холбоотой бүх төрийн байгууллагад цаас, хэвлэлийн зардал, шуудан, тээврийн зардал хэмнэх боломжтой боллоо.



meduuleg.iaac.mn